



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 31 өдөр


Дугаар А/343

Ховд

Буцалтгүй тусламж олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.17, 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын төр, нийгмийн зүтгэлтэн, Ховд аймгийн Ардын Депутатуудын Хурлын гүйцэтгэх захиргааны дарга асан Жамбын Норовсамбуугийн буяны ажилд 500000 төгрөгийн буцалтгүй тусламж олгосугай.
2. Буцалтгүй тусламжид олгох 500000 төгрөг (таван зуун мянга)-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхболд)-д зөвшөөрсүгэй.



Б.ДҮГЭРЖАВ